



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 08 өдөр

Дугаар A/150

Зуунмод

Дайчилгаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, 29.2, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.13, 10 дугаар зүйлийн 10.4.4, 19 дүгээр зүйлийн 19.1, 32 дугаар зүйлийн 32. 1.9% Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт “Гамшигийн үед дайчилгаа зохион байгуулах журам”-ын 2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зуунмод суманд Коронавирусийн халдвартын цар тахлын тохиолдол илэрсэнтэй холбогдуулан МХБХ-ны “Шигшээ багийн бэлтгэлийн төв”-ийг халдварт илэрсэн иргэдийн ойрын болон дам хавьтлыг тусгаарлах зорилгоор дайчилсугай.
2. МХБХ-ны “Шигшээ багийн бэлтгэлийн төв”-ийн дарга удирдлагад тусгаарлагдах иргэдийг хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх, байрны бэлэн байдлыг хангаж ажиллахыг даалгасугай.
3. Тусгаарлан ажиглах байрны халдварт хамгаалал, бэлэн байдалд үзлэг шалгалт хийж заавар зөвлөмж өгч ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (У.Өлзийцэцэг)-т үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ц.Буманбуян)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МОНХБААТАР

